



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/134

Улаанбаатар хот

Ажлын хэсгийг томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.5, 46.1.7, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын бүтцийн нэгжүүдийн барилга засварын ажилд захиалагчийн зүгээс хяналт тавьж, барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын гүйцэтгэлийг хангуулах зорилгоор Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Урантулга

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, дэд хурандаа,

Гишүүд:

Ж.Төмөрмандах

Дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн дарга, хошууч,

Д.Даваасүрэн

Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа,

Л.Чинбат

Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа,

Нарийн бичиг:

А.Чинбат

Хангалт үйлчилгээ орон сууц, байрны ашиглалт хариуцсан мэргэжилтэн, дэд хурандаа

2. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, дүрэм журмыг баримтлан чанар, стандарт, техникийн үзүүлэлтийн дагуу хүлээн авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, дэд хурандаа Д.Урантулгад үүрэг болгосугай.

3. Гэрээт ажил дууссаны дараа гэрээ, холбогдох тендерийн баримт бичгийг холбогдох материалыг бүрдүүлэн архивд хүлээлгэн өгөхийг Санхүү эдийн засгийн хэлтсийн Хангалт үйлчилгээ орон сууц, байрны ашиглалт хариуцсан мэргэжилтэн, дэд хурандаа А.Чинбатад даалгасугай.

ДАРГА,

ХУРАНДАА

Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

